


# Ажил хийдэг хүүхдүүд

## 24



Өнөөгийн үйлдвэрийн газрууд нь хүүхэд ажиллахад аюулгүй газар биш юм. Үйлдвэрийн ажлын нөхцөл нь хүүхдийн өсөн торниж буй бие организмд хор хохирол учруулж, эрүүл саруул нас биед хүрэх боломжийг нь багасгах хэмжээнд хор хохирол учруулах болно. ОУХБ-ын үзэж байгаагаар, “Хүүхэд үйлдвэрийн дамжлага дээр биш, сургуульд байх ёстой” юм.

Та болон таны нэгдэн орсон эвлэл, холбоо эсвэл олон нийтийн байгууллага нь хүүхдийг сургуульд нь үлдээж, үйлдвэр дэх хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийг зогсоход туслах болно.

- **Ажил хийдэг хүүхэд болон тэдний гэр бүлтэй холбоо тогтоож** тэдний хэрэгцээ шаардлагыг олж мэдэн, тус болох шийдэл олох хэрэгтэйг тэдэнд ойлгуул.
- **Даргатай нь** ажил хийж байгаа хүүхдэд шударга хөлс өгөх, ажил хийж байгаа хүүхдийг сургуульд явахад нь туслах талаар **тохиролц**
- Дарга нь хэтэрхий жаахан хүүхэд ажилд авах эсвэл тэдэнд аюултай ажил өгөх зэргээр **хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдалтай эвлэрэн ажиллахаас татгалз**.
- **Хууль бусаар хүүхдийг ажилд авч байгаа үйлдвэрүүдийг эрх баригчдад, бас хүүхдийн халамжийн агентлагт мэдээлснээр** тэд хүүхдийг хөдөлмөр эрхлэхийг нь болиулж сургуульд явуулахын зэрэгцээ орлого олоход нь тусалж чадна.

- Үйл ажиллагаа явуулан хүүхдийг хамгаалж, хууль бусаар ажилд авч байгаа хүмүүсийг шийтгэж, **хууль эрх зүйн хүрээнд ялалт байгуул.**
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалингийн төлөө буюу тэдний гэр бүлийг боломжийн амьдралтай байлгах, хүүхдүүдийг нь сургуульд нь явуулах, **хүүхдийн халамж авах боломж олгохын төлөө зохион байгуулалтад ор.** 378-р хуудсыг үз.

## Үйлдвэрийн ажил хүүхдэд илүү их хор нөлөө үзүүлдэг

Ажлын аюул нь насанд хүрсэн хүний нүүр тулж байгаагаас өөрөөр хүүхдэд нөлөөлдөг. Үүнд дуу чимээ, тоос, химийн бодис, гал, бас дахин давтах нэг жигдийн хөдөлгөөн орно.

Ажлын аюултай нөхцөл нь хүүхдийн бие бялдар, оюун санаа нь боловсорч гүйцээгүй үед илүү их хор хөнөөл учруулан, гэмтэл өгч өвчинд өртөмтгий болгодог. Ажлаас шалтгаалах гэмтэл, өвчин нь хүүхдийн хөгжлийг удаашруулж, хөдөлмөрийн чадваргүй болгох ба ингэснээр тэднийг сурах, ажиллах эсвэл нас биед хүрээд илүү сайн ажилтай болох боломжгүй болгодог.



**Үйлдвэрийн ажлыг гэртээ хийж байх үед хүүхдийн хөдөлмөрийг ашиглах байдал тохиолдож болно.**

### Ажил хийдэг өсвөр насныхан

**Хүүхдийн хөдөлмөр** буюу хүүхэд ажил хийснээр тэдний эрүүл мэнд, хөгжил болон боловсролд нь хор нөлөө үзүүлдэг. Хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс ихэвчлэн тухайн улсдаа ажил хийж болох насанд хүрээгүй бага насных байдаг. Тэд бас ажиллангаа сургуульд явах хэрэгтэй байдаг. Үйлдвэр дотор хүүхдийн хөдөлмөр харьцангуй бага байдаг ч жижиг цехэд эсвэл гэрээрээ үйлдвэрлэл эрхэлж байгаа бол тэнд хүүхдийн хөдөлмөр оролцож байдаг.

Дэлхийн олон оронд сургуулийн насны хүүхдийг зарим төрлийн ажил хийхийг зөвшөөрдөг бөгөөд ихэнхдээ гэртээ эсвэл гэрийнхээ бизнесийн ажлыг хийдэг. Хууль нь магадгүй сургуулийн насны хүүхдэд тодорхой төрлийн ажлыг тодорхой цагт хийхийг зөвшөөрдөг байж болох юм. Гэхдээ хүүхэд химийн бодис болон аюултай нөхцөл байдалд өртөхгүй, бас сургуульдаа явах, сурах, тоглох, бас амрах хангалттай цагтай ажиллах нь тэдэнд хор хөнөөл учруулдаггүй.

**Өсвөрийн ажилчид** буюу 15-18 насны хүүхдүүд. Хуулийн дагуу хөдөлмөрлөх нас нь 18 гэж заасан байдаг ч үүнээс доош насны хүүхдүүд ихэвчлэн хөдөлмөр эрхэлдэг. Өсвөрийн ажиллагчдыг хуулийн нүдээр “хүүхэд” биш гэж үздэг ч ахмад ажиллагчдын зүгээс тэднийг хангалттай ур чадвартай биш гэж шүүмжилдэг. Тэдний бие, оюун санаа үргэлжлэн өсөж байхдаа химийн бодис, олон давтамжит үйлдэл бүхий ажилд өртсөнөөр ахмад ажиллагчдаас илүү хордож, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж байдаг. Ихэвчлэн тогтмол мөнгө олох шаардлага нь тэдний цаашдын боловсрол олж авах боломжийг үгүй хийдэг. Эдгээр шалтгааны улмаас үйлдвэрийн ажил хүүхдэд насанд хүрсэн хүнээс ч илүү хор нөлөө үзүүлж байдаг.

## Хүүхдүүд насанд хүрэгчдээс илүү их гэмтдэг

Зарим үйлдвэрийн эзэд хүүхдүүдийг илүү хурдан хуруутай байдаг учраас тодорхой ажилд авдаг. Хэдий тийм ч хүүхдүүд насанд хүрсэн хүмүүс шиг өөрсдийн бие болон хөдөлгөөнөө хянах чадвар муу, бас жижиг учир илүү их гэмтэл авах магадлалтай байдаг. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүүхдийн жижиг биед биш насанд хүрсэн хүнд зориулж хийсэн байдаг.

## Хүүхдэд нөлөөлөх аюул

**Дуу чимээ:** өсвөр насны хүүхдүүд нь насанд хүрэгчдийг бодвол сонсголоо алдах илүү их эрсдэлтэй байдаг. Дуу чимээнд өртөлтийн хязгаар нь насанд хүрэгчдэд аюулгүй гэж тогтоосон ч хүүхдүүдэд тийм биш юм. 13-р бүлэг: Дуу чимээ хэсгийг үзнэ үү.

**Халуун:** Өсвөрийн ажиллагчид нь насанд хүрэгчдийг бодвол халууныг тэсвэрлэх чадвар муу байдаг. Насанд хүрэгчдэд аюулгүй орчин нь хүүхдэд аюулгүй гэсэн үг биш юм. 15-р бүлэг: Халуун ба хүйтэн нөхцөл хэсгийг үз.

**Хүнд ажил:** Хүнд ажил нь өсөж өндийж буй ясанд хэт их стресс үүсгэж болох бөгөөд ингэснээр ясны гэмтэл эсвэл өсөлтийн согог үүсэх шалтгаан болдог.

**Химийн бодис:** Хүүхдүүд химийн бодисоос дараах шалтгааны улмаас илүү амархан, бас ноцтой хохирдог:

- Насанд хүрэгчидтэй адил хэмжээний бодист өртөхөд тэдний биеийн жин бага учир илүү өндөр тунгаар хорддог;
- Тэдний бие өсөлтийн насандаа химийн хорт бодист илүү өртөмтгий байдаг. Ажил дээрх хордолт нь хүүхдийн өсөж буй дотор эрхтэн, гормоны харьцаа, арьсыг гэмтээж, хорт хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг;
- Тугалга, төмөрлөгийн уурыг хүүхдийн бие, тулгуур эрхтэн, яс нь насанд хүрэгчдийнхийг бодвол илүү хурдан шингээж, суралцах, хөгжихөд нь асуудал үүсэх шалтгаан болдог;
- Хүүхдүүд насанд хүрэгчдээс илүү хурдан амьсгалдаг учир агаарын бохирдлоос болж өвдөх магадлал өндөр байдаг;
- Хүүхдүүд намхан тул газраар овоорсон химийн бодист хүрэх эсвэл амьсгалах, идэх, залгих магадлал илүү их байдаг.



## Биеийн хөгжлийн удаашрал

Ажил хийж буй хүүхдүүд өсөлтийн асуудал, биеийн хөгжил нь удааших зэргээр дараах байдлаас болж зовж шаналж байдаг:



**Хордсон хүүхэд магадгүй илүү удаан сурдаг, цочирсон, бас тогтворгүй эсвэл удаан өсөлтийн бусад шинж тэмдэг илэрдэг.**

**Хөдөлгөөнгүй байдал:** Ажиллагч хүүхдүүд ихэвчлэн тоглож, хөрштэйгөө танилцаж эсвэл бусад хүүхдүүдтэй харилцаж чаддаггүй. Мөн тэд эрүүл өсөж хөгжихөд нь шаардагдах түвшинд хангалттай амарч чаддаггүй.

**Хордох:** Ажил хийж байгаа хүүхдүүд хордон толгой өвдөх, амьсгалын замын хүндрэл, урт хугацааны нөхөн үржихүйн эрхтний асуудал, хорт хавдар эсвэл бүр үхэлд ч хүргэх аюултай тулгардаг. Хордлого нь хүүхдүүдийн оюуны чадавхад сөрөг нөлөөтэй.

**Хүнс тэжээлийн дутагдал:** Зарим хүүхдүүд гэр бүлээ тэжээхийн тулд ажилладаг. Үйлдвэрт ажиллаж байгаа хүүхдүүд ихэвчлэн ажиллаж байхдаа хоолоо хойш нь тавих буюу үйлдвэрлэлийн нормдоо хүрэхийн тулд хоолгүй ажилладаг. Хатангир биетэй давжаа хүүхдүүд бусад хүүхдээс илүү эрүүл мэнд муутай, хараагүй болсон, өсөлт нь зогссон, суралцах чадваргүй, бас бусад хүүхдүүдтэй харьцуулахад эрч хүчгүй, дорой болдог.

## Суралцах боломжоо алдах

**Уйтгартай ажил:** Хүүхэд энгийн, уйтгартай, нэгэн хэвийн ажил хийснээр сургуульд явж, бас тоглож, оюун ухааны болон нийгэм, олон нийт дунд биеэ авч явах чухал ур чадварт суралцаж чаддаггүй.

**Сургууль засвардах:** Хүүхдийн хөдөлмөр эрхлэгч нь ихэвчлэн сургуулиа төгсөж чаддаггүй тул уншиж, бичиж эсвэл тоо бодож чаддаггүй. Боловсрол эзэмшиж чадаагүй хүүхэд нас биед хүрсэн хойноо ажилд орох боломж багатай байдаг.

## Нөүрийн түүх

Нөүр нь Малайзийн Селангор мужийн Сэрданг Лама гэх жижиг тосгонд амьдардаг. Тэр долоон настайгаасаа хойш цамцны жижиг үйлдвэрт ажиллаж байна.

Тэр үйлдвэрлэсэн цамцыг савладаг. Тэр долоо хоногт 6 удаа өглөө 8.30-аас орой 5.30 хүртэл ажилладаг. Түүнд бусад хүүхдүүдтэй хамт тоглох цаг байдаггүй.

“Би сургуульд явахыг хүсэж байна. Гэвч надад мөнгө байхгүй. Тиймээс би эндээ үргэлжлүүлэн ажиллах болно.”



## Хүүхдийн хөдөлмөр зохистой байгааг илтгэх шинж тэмдэг

- Хүүхэд хуулийн зохицуулалттай ажиллах болон гэр бүлийн бизнест ажиллах хууль ёсны насанд хүрсэн байх;
- Хүүхэд сургуульд явдаг, бас сурах, тоглох, амрах цагтай байх;

(үргэлжлэл)

- Хүүхэд анхаарал халамжийг авдаг, эрүүл, бас аз жаргалтай харагдах;
- Ажил нь хүүхдийн нас, бие, сэтгэхүйн боломжид нь тохиромжтой байх;
- Эрэгтэй болон эмэгтэй хүүхдүүд адил тэгш ажиллах боломжтой;
- Хүүхэд анхаарал халамжтай, бас хариуцлагатай насанд хүрсэн хүнээр удирдуулах;
- Ажлын байр нь хүүхдийн амьдрал, эрүүл мэндийг хамгаалсан байх;
- Ажил нь зохистой цалинтай, хүүхдэд ирээдүйд илүү сайн ажилтай болох ур чадвар олгосон байх;
- Хүүхэд гэр бүлийнхээ өрийг төлөхийн тул ажиллаагүй байх.

### **Хүүхдийн хөдөлмөр хор хөнөөлтэй байгаагийн шинж**

- Хүүхэд сургуулийн насных боловч сургуульд явдаггүй байх;
- Хүүхдийн нас, хийж байгаа ажил нь улсын эсвэл олон улсын хуулийг зөрчсөн байх;
- Хүүхэд ядарсан, бохир, хагас өлсгөлөн, өвчтэй эсвэл аз жаргалгүй харагдах;
- Хүүхэд гэр бүл нь ядуу, хаягдмал эсвэл эрүүл бус байдал, эцэг эх нь нас барсан учраас хүчээр ажилладаг байх;
- Сургууль хүлээн авахаас татгалзсан учраас ажиллах ёстой болсон охид байх;
- Хүүхэд зохистой цалин авдаггүй байх;
- Хүүхэд маш бага цалинтай эсвэл огт цалингүй ажилладаг байх;
- Хүүхэд зааж удирдах хүнгүй эсвэл хүчирхийлдэг хүнээр удирдуулан ажилладаг байх;
- Хүүхэд сургуулийн цагаар, суралцаж байх цагтаа эсвэл хэт орой, хэт эрт ажилладаг байх;
- Ажил нь аюултай, эрүүл бус, эсвэл хүүхдийн нас, бие бялдар болон сэтгэцийн чадварт нь ахадсан, хийхэд хэтэрхий хэцүү байх;
- Хүүхэд сэтгэл хөдлөлийн, хэл ярианы, биеийн эсвэл бэлгийн дарамттай нүүр тулдаг байх.

# Хүүхдийн хөдөлмөрийн шалтгаан

Гэр бүл нь ядуу, өртэй эсвэл өнчин хүүхдүүд ихэвчлэн сургуульд явахын оронд ажилладаг.

## Ажилгүйдэл ба амь зуух мөнгөгүй байх

Ажиллаж буй насанд хүрсэн хүмүүсийн долоо хоногийн цалин гэр бүлээ дэмжихүйц хангалттай байх хэрэгтэй. Хэдий тийм ч бага цалин, ажлын байрны тогтворгүй байдал, ажилгүйдэл зэргээс үүдэн олон гэр бүл ядуу зүдүү амьдарч байна. Экспортын чиглэлийн үйлдвэрийн ажил нь ихэвчлэн гэр бүлээ тэжээхэд хүрэлцдэггүй бага цалинтай учир хүүхдүүд нь ажиллах ёстой болдог.

Ажил олгогчид нь хүүхдүүдэд насанд хүрэгчдээс бага цалин өгөх учраас тэднийг ихэвчлэн ажилд авдаг. Гэсэн хэдий ч тэд хүүхдүүдийг насанд хүрэгчид шиг ажиллана гэсэн хүлээлттэй байдаг.

## Ажилд сургах хуурамч амлалт

Хүүхдүүд болон өсвөр насныханд ирээдүйд ажиллах ур чадварыг энэ ажил нь заах болно гэж амладаг учраас тэд цалингүй эсвэл маш бага цалингийн төлөө ажилладаг. Олон оронд үйлдвэрүүд нь хуулийн дагуу дадлагажигчийн цалин олгох ёстой. Гэвч тэд өсвөр насныханд урт хугацаагаар бага цалин өгч эвтэйхэн хариуцлагаас мултрахыг оролддог.

## Өвчлөл ба эрүүл мэндийн үйлчилгээний хангалтгүй байдал

ДОХ, сүрьеэ, хумхаа өвчин, бас эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй зэргээс болж хүмүүс өөрсдийн хүүхдэдээ анхаарал тавих чадвар нь дорддог ба үүнээс болж хөдөлмөрийн чадвараа алдсан эсвэл өвчтэй байгаа тэжээгчийнхээ оронд хүүхдүүд ажилладаг. Эдгээр хүмүүс нь эмнэлэгт эмчлүүлэх болон эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой, бас ажил нь хангалттай эрүүл хүнс авах болон эрүүл орчинд амьдрахад нь хүрэлцэхүйц цалин өгдөг байснаар өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

## Сургуульд сурах боломжгүй байх

Олон оронд бүх хүүхэд сургуульд явж боловсрол эзэмшинэ гэсэн хуультай байдаг ч маш олон хүүхдэд боловсрол эзэмших боломж олдохгүй хэвээр байна. Тэд сургуульд сурах боломжгүй эсвэл сургууль нь хэт хол, мөн сургуульдаа явах тээврийн хэрэгсэлгүй байдаг. Охид ихэвчлэн ах нарынхаа сургалтын төлбөрийг

төлөхөөр эрт сургуулиа хаядаг ба хар нялхаараа гэрлэ гэх дарамтад ордог.



## Хүүхдийн хөдөлмөрийг хориглох ба хүүхдийг хамгаалах

Үндэсний засгийн газар нь залуусын тогтмол цалинтай ажиллаж эхэлж болох хамгийн доод насыг тогтоодог. Энэ нь ихэвчлэн хуулиар заавал сурах ёстой сургуулиа дүүргэсний дараа буюу ажлын төрлөөс хамаарч 12-15 насны хооронд байдаг. Чинээлэг үйлдвэржсэн улсад илүү олон жил сургуульд сурсан байхыг шаарддаг тул залуус 17-18 настай болсон хойноо ажиллаж эхлэхийг зөвшөөрдөг. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) болон Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь хүүхдийн хөдөлмөр эрхлэх хамгийн бага насыг ерөнхийд нь 15 гэж тогтоосон байдаг.





## НҮБ ба ОУХБ Хүүхэд ба Ажил эрхлэлт сэдвээр



НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхэд гэж 18 нас хүрээгүй хүн бөгөөд тухайн улсын засгийн газраар хамгаалагдсан байх ёстой.

- Хүүхэд сурч боловсрох эрхтэй;
- Хүүхэд амрах, тоглох, бас чөлөөт цагтай байх эрхтэй;
- Хүүхэд нь аюултай байж болох, хүүхдийн боловсролд саад учруулж байгаа ажил эсвэл хүүхдийн эрүүл мэнд, бие, сэтгэц, нэр төр, ёс суртахуун, нийгмийн хөгжилд нь саад болж буй ажлыг хийж болохгүй;
- Засгийн газар нь тогтмол ажиллаж эхлэх насны доод хязгаарыг заавал тогтоож, ажлын нөхцөл, цагийг журамлаж, бас хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн нийгэмших, биеийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээлтийг дэмжих ёстой.

**ОУХБ-ын хөдөлмөрлөх насны доод хэмжээны тухай конвенц (№138), Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд конвенц (№182)-д заахдаа:**

- Хүүхэд нь 12-13 наснаасаа эхлэн хөнгөн ажил хийж болох ч тэдний сургуульд явах, амрах, тоглоход нь саад болох эсвэл эрүүл мэндэд нь муугаар нөлөөлөх нөхцөлтэй байж болохгүй;
- Ажиллаж болох хамгийн бага нас 15;
- Аюултай ажил хийж болох хамгийн бага нас 18;
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох ёстой.

**ОУХБ-ын Залуучуудын эрүүл мэндийн үзлэг конвенц (№77)-д заахдаа:**

- Залуучууд болон хүүхдийг ажиллаж эхлэхээс нь өмнө болон ажиллаж байгаа үед нь жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулах ёстой.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг  
Хавсралт А-д тайлбарлав.

## Үндсэн шалтгааныг анхаарах

Хүүхдийн хөдөлмөрийн үндсэн шалтгааныг устгахын тулд бидэнд хүүхэд бүрийн боловсролыг дэмждэг, ядуурлын эсрэг ажилладаг эдийн засаг хэрэгтэй.

- **Бүх ажилчид илүү сайн нөхцөлд ажиллаж, цалин авахын тулд эвлэлдэн нэгд.** Ингэх нь гэр бүлдээ тус нэмэр болохын тулд хүчээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн тоог багасгана;
- Насанд хүрэгчдийн илүү сайн цалинтай болох чадварыг сайжруулахын тулд тэднийг **боловсрох боломж болон ажлын сургалтаар ханга;**
- Ажиллагчдын цалин болон урамшуулалд хөдөлмөрийн хөлс, цалин, илүү цагийн төлбөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээ болон жирэмсний тэтгэмж орох ёстой гэсэн **хуулийг сахиул.**

### Ажиллагч хүүхдүүдийн холбоо

Намайг Бангкокийн үйлдвэрт хэдэн жил ажиллаж байх үед найз маань надад Ажиллагч Хүүхдүүдийн Клубийн талаар хэлсэн юм. Клуб нь ажилчин хүүхдүүдийг зохион байгуулалтад орж, эрхээ мэддэг болоход тусалдаг. Энэ нь мөн ажил олгогчдод зориулсан хөтөлбөр болон хүүхдүүдийг илүү сайн ирээдүйд бэлтгэх боломж олгох хөтөлбөртэй.

Би клубийн уулзалтад очиж эхэлсэн ба тэдний ажилтан намайг манай клубийн зохион байгуулагчаар бүтэн цагаар ажиллахыг дэмжсэн юм. Би ажиллагч хүүхдүүдийн ажлын байранд очиж, ажлын нөхцөлийн талаар олж мэддэг байв. Тэгээд бид ажиллагч хүүхдүүдийн эрхийн талаар ярилцаж, тэднийг манай клубийн үйл ажиллагаанд ирвэл илүү ихийг сурч авч болно гэж зоригжуулдаг. Би сонинд болон заримдаа үйл ажиллагаанд туслахаар баримттай зүйлс бичдэг.

Үйлдвэрт ажиллаж байхдаа, бүхэл өдрийн турш өөр юуны ч талаар бодолгүйгээр зөвхөн нормт ажлаа дуусгахын тулд ажилладаг байв. Харин энд бол би маш олон зүйлийг бодох ёстой. Зохион байгуулна гэдэг нь миний хийж байсан бусад бүх зүйлсээс илүү хэцүү юм. Заримдаа их санаа зовж гарахыг хүсдэг ч эндхийн ажилтнууд намайг үргэлжлүүлэн ажиллахыг дэмжсэн. Одоо би ажилдаа дажгүй сайн болсон.



**Прасэрт бол Тайландын зүүн хойд мужийн Хон Хаенаас гаралтай залуу хүү**

## Бүх хүүхдэд боловсрол олгохын тулд

Боловсрол эзэмших сургууль нь ойрхон, хүүхдийн сонирхол, хэрэгцээнд тохирсон, бас сайн чанартай, үнэгүй (эсвэл ядаж бололцооны үнэтэй) байх хэрэгтэй. Хэрвээ ажилчид ажил олгогчийг ажиллагч хүүхдүүдийг хал гэж шаардвал хүүхдүүд амьдрахын тулд түүнээс ч хэцүү ажлыг олж хийх болдог. Хүүхдүүдэд ажиллахаас гадна хоёр дахь хувилбар байлгахын тулд гэр бүлийнх нь ядуурлыг бууруулах замаар хүүхдийг заавал сургуульд явуулах ёстой. Байгууллага нь дараах зүйлсийг хийж чадна:

- **Ажиллагч хүүхдүүдэд үнэгүй сургууль олж өгөх**, мэргэжлийн сургалт санал болгох, мөн тэнд нь тэжээллэг үнэгүй хоол санал болгодог тийм сургалттай газрыг олоход туслах;
- **Хүүхдийн олсон орлогыг орлуулахын тулд гэр бүлд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх** боломжийг хайх;
- **Өнчин ажилчин хүүхдүүдэд хоол, бас амьдрах газар өгснөөр** тэд ажиллахын оронд сургууль болон мэргэжлийн сургалтад хамрагдаж чадна;
- **Хэрвээ эцэг эх нь салсан бол хүүхдийг гэр бүлийнхэнтэй нь дахин холбоо тогтоолго.**

### Сургуулийн хөтөлбөрт зориулсан мөнгө нь хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхэд тусална

Хүүхдийн хөдөлмөрийг зогсоохын тулд Бразил улсын засгийн газар, Бразилийн мужуудад ядуу гэр бүлд туслах буцалтгүй тусламжийн хөтөлбөр эхлүүлэв. Ихэнх ажил хийдэг хүүхдүүдийн гэр бүл нь тэдний ажиллаж олж байгаа мөнгөнөөс хамааралтай байв. Энэ хөтөлбөрийг тэд Босла Эскола (сургуулиар хангах) гэж нэрлэдэг ба ядуу гэр бүлд сургуульд тогтмол явдаг хүүхдийн (5-17 настай) тоогоор сар бүр тэтгэлэг өгдөг юм. Энэ мөнгө нь гэр бүлийн орлогод хувь нэмэр болж, тэдэнд наад захын хэрэгцээгээ хангах боломжийг олгодог.

Босла Эскола нь ажиллахын оронд сургуульд явах боломжийг хүүхдүүдэд өгсөөр байна. Сургуульд хамрагдалт зарим орон нутагт хоёр дахин нэмэгдэж, хүүхдүүд сургуульд хамрагдах өдрөөсөө илүү цөөн өдөр алддаг болов. Босла Эскола одоо улс даяар хэрэгжсэн хөтөлбөр болсон байна. Энэ нь Босла Гэр бүлүүдийн (гэр бүлийн буцалтгүй тусламж)

(үргэлжлэл)

нэгдсэн хөтөлбөр болж, гэр бүлүүдэд хүүхдүүдээ вакцинд хамруулах мөнгө олгодог болжээ. Хөтөлбөр нь мөн Латин Америк болон Африкийн зарим улсуудад хэрэгжих болов.

## Засгийн газар хүүхдийн эрхийг хангах ёстой

Энэхүү ажлыг засгийн газраар хийлгэх шаардлага тавихдаа:

- Олон улсын конвенц, улс, муж, орон нутгийн хуульд **хүүхдийн эрхийн тухай гэрээ** хэлэлцээрийн заалтыг оруулж сахиулах;
- **Сургуулийн насны хүүхдийн хөдөлмөрт хуулиар хязгаарлалт тавь:** Хууль нь ихэнхдээ ажлын цаг, өдрийн аль цагт нь ажиллаж болох талаар ажиллагч хүүхдүүдийг хамгаалдаг. Энэ нь тэдний сургуульд явах цаг, суралцах, тоглох, бас амрах цагтай давхцахаас сэргийлдэг. Хязгаарлалтууд нь ихэвчлэн хүүхдүүдийг гэмтээж болох ажил хийхээс буюу цахилгаан багаж ашиглах, аюултай тоног төхөөрөмжийн ойр ажиллах, хэт халуун хэсэгт ажиллах, бас хүнд зүйлс өргөхийг хориглодог;
- **Хүүхдийг ажил хийлгэхийн тулд сургуулиас нь зөвшөөрөл ав:** Зарим улсад ажил олгогч нь ажилд авч байгаа хүүхэд болгоны зөвшөөрлийг сургуулиас нь авдаг. Зөвшөөрөл нь хүүхэд сургуульдаа явж байгааг, бас ажил олгогч нь хүүхдийн хөдөлмөрийн хязгаарлалтыг мэдэж байгааг харуулдаг;
- **Өнчин хүүхдийн хөтөлбөр хэрэгжүүл:** Орон нутгийн өсвөр үеийн төвүүд нь өнчирсэн эсвэл гэр оронгүй, бас өөрсдийгөө тэжээхийн тулд зайлшгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд санаа тавих олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн газар байж чадна;
- **Гэр бүлийн орлогыг дэмжих сан:** Наад захын хэрэгцээний зүйлст зориулсан буцалтгүй тусламж, хүүхэд асрах, нэгдсэн гал тогоо ба хүнс, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдсан байдал, боловсрол, хүүхдүүдийг сургуульд нь байлгахын тулд гэр бүлүүдэд туслах, насанд хүрэгчдэд амьдрах орлоготой байхад нь туслах ажлын сургалтын хөтөлбөрт үндэслэн олон нийтийн хөтөлбөр бий болго.

### Бразилд үйл ажиллагаа явуулдаг холбоод

Ажилчдын Нэгдсэн Холбоо (CUT) нь Бразилд хүүхдийн хөдөлмөрийг зогсоох зохион байгуулалтад орсон үндэсний хөтөлбөр юм. Эхэндээ тэд судалгааны төвүүд болон их сургуулиудтай хамтран хүүхдийн хөдөлмөр, бүс нутаг дахь хүмүүсийн хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн санаа бодлыг судалсан байна. Хүмүүсийн ихэнх нь хүүхдүүд хотын бүсэд ажиллах нь хөдөө орон нутагт ажилласнаас илүү дээр гэж үзэж байв. Тэд хэлэхдээ “Дор хаяж, тэд зүгээр л гудамжинд амьдраагүй, бас ажиллаж байна.” гэв.

Дараа нь тэд хүүхдийн хөдөлмөрийг зогсоох тэмцлийг дэмжигч бүлгүүд бий болгохоор оролдов. Тэд радио, ТВ-ийн хөтөлбөр, сонин, товхимол, зурагт самбар, бичлэг болон фото зургийн үзэсгэлэнг ашиглаж, ажиллагч хүүхдүүдийн нөхцөл байдлын талаар мэдээлж эхлэв.

Мөн ажил олгогчийг хүүхдийн хөдөлмөрийн талаар ярихыг дэмжив. Холбоод нь хүүхдүүдээр аюултай ажил хийлгэхийг зогсоосон ба хүүхдүүд болон тэдний гэр бүлийнхэнд тусламж үзүүлэн ажиллаж байна. Энэ хөтөлбөр нь боловсрол, орлогын дэмжлэг, амралтын хөтөлбөрийг бий болгосноор хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхэд нэг алхам урагшилсан юм.